




СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт буюу хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

Тайланг
бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг
дахь Төрийн
Аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Ч.Энхтуяа

Аудитын
менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
Б.Наранчимэг

Аудитор
Б.Эрдэнэзул
Ж.Цогт

2017 оны 12 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70362442, 70363036
дугаарын утас,
selenge@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

ХАЯГ:

Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум,
аймгийн ЗДТГ-ын
байрны өргөтгөлд

Агуулга

Товчилсонугийн

жагсаалт..... Аудит хийх
үндэслэл..... Аудитын
зорилт.....
Аудитын хамрах хүрээ.....
Арга
зүй.....
Шалгуур үзүүлэлт,
хугацаа.....
Ерөнхий мэдээлэл.....

**БҮЛЭГ.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг холбогдох
хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна.**

- 1.1. Аймаг, сумдын Засаг дарга нар дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах төлөвлөгөө гаргаагүй байна.
- 1.2. Төсөл боловсруулах төлөвлөгөөний чухал хэсэг болох нөхцөл байдлын дүн шинжилгээг журмын дагуу хийгээгүй байна.
- 1.3. Сумдын Засаг дарга нарын боловсруулж, батлуулсан хөтөлбөрүүдэд нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу хийгээгүй бөгөөд төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна.
- 1.4. Аймаг, сумдын Засаг дарга нарын боловсруулж, ИТХ-аар батлуулсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцож, тусгаагүй байна.
- 1.5. Аймаг, сумдын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг холбогдох шатны ИТХ-аар батлуулсан байна.
- 1.6. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль, журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна

**БҮЛЭГ.2 Хөгжлийн бодлогын баримт, бичгийн хэрэгжилтийн
явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах хоёр өөр чиг
үүргийг давхардуулан гүйцэтгэж байна.**

- 2.1. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг баталсан хугацаанд тайлагнаагүй байна.
- 2.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг шинэчлэн батлагдсан хууль, журамтай нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- 2.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнах үүрэг бүхий албан тушаалтнууд нь хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг давхардуулан гүйцэтгэж байна.

**БҮЛЭГ.3 Олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг орон
нутгийн захиргааны байгууллагууд хангалтгүй зохион байгуулж
байна.**

- 3.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажил хангалтгүй байна.
- 3.2. Орон нутгийн ИТХ, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ нь бодлогын бичиг баримтуудыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Дүгнэлт.....
Зөвлөмж.....
Хавсралтууд.....
Холбогдох байгууллагын санал.....

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ЕА	Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДО	Засаг даргын орлогч
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
НАГ	Нийцлийн аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийсэн үндэслэл:

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “ Аудитын сэдэв батлах тухай “ 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт- шинжилгээ үнэлгээ хийсэн эсэх.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх.

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж, мөрдөж эхэлсэн 2016 оны 01-р сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрыг хамруулав.

3. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгадагч байгууллагуудаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэргээр нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

“Төсвийн тухай хууль”, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Засгийн газрын тухай хууль”, “Хууль тогтоомжийн тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх “Үндэсний хөтөлбөрийн жагсаалт”, “Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр”, “Аймаг сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр”, бусад холбогдох хууль, дүрэм, журам, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Б.Наранчимэг, аудитор Б.Эрдэнэзул, Ж.Цогт нар 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 12 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

5. Ерөнхий мэдээлэл

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1¹ дэхь заалтыг үндэслэн “Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр”-ийг Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2007 оны 05-р сарын 03-ны өдрийн 38 дугаар тогтоолоор баталсан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл “Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд “Аймаг, сумын засаг даргын нарын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020 он”, уг хөтөлбөрийн зорилттой нийцүүлсэн 13 дэд хөтөлбөр, “Богино хугацааны буюу 1 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд “Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” зэрэг баримт бичгүүдийг боловсруулан аймаг, сумдын ИТХ-аар хэлэлцүүлэн, батлуулсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой 8 журам, 5 бодлого, 2 төлөвлөгөөг боловсруулж мөрдөхөөр төлөвлөжээ.

Аудитын явцад Ерөө, Хушаат сумдын удирдлагаас аудитад шаардлагатай баримт материалыг удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй тул эдгээр сумдын хөгжлийн бодлогын баримт бичгүүд аудитад хамрагдаагүй болно.

АУДИТЫН ДҮН

Бүлэг 1

Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх?

Хөгжлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулаагүй байна.

1.1. Аймаг, сумдын Засаг дарга нар дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах төлөвлөгөө гаргаагүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “... Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны ИТХ-аар батлуулна” гэсэн заалтын хүрээнд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг 27 дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт аймгийн

¹ Төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар: а. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэвийн болон жилийн үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

ИТХ-аар батлуулсан бол сумдууд Засаг даргын мөрийн хөтөлбөрөө дэд хөтөлбөрийн жагсаалтгүйгээр батлуулсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан жагсаалтаар батлагдсан 27 дэд хөтөлбөрөөс 7-г боловсруулан аймгийн ИТХ-р батлуулсан бол 12 нь боловсруулалтын шатандаа, 8 нь боловсруулагдаагүй байна. */Хавсралт-1/*

Хэдийгээр сумдын Засаг дарга нар нь дэд хөтөлбөрийн жагсаалтыг тус тусын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй хамт батлуулаагүй боловч мөрийн хөтөлбөрөөс нь түүж үзэхэд нийт 64 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 7 хөтөлбөрийг боловсруулан сумдын ИТХ-р батлуулсан бол 9 нь боловсруулалтын шатандаа, 48 нь боловсруулагдаагүй буюу хэрэгжих хугацаа нь тодорхойлогдоогүй байна. */Хавсралт-2/*

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг мөрдөж эхлэхээс өмнөх хугацааны аймгийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөртэй уялдуулан 2009-2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 21 дэд хөтөлбөр, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан 8 дэд хөтөлбөр он дамжин хэрэгжиж байна. */Хавсралт-3/*

Засаг дарга нь аймаг хөгжүүлэх хэтийн зорилт болон дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байхаар журамласан */Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 13, 17-р заалт/* атал аймгийн ИТХ-аар батлуулсан 7 дэд хөтөлбөрт ажлын хэсэг ч байгуулаагүй, төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй бол боловсруулах шатандаа байгаа 12 дэд хөтөлбөрт ажлын хэсэг байгуулсан ч төлөвлөгөө боловсруулаагүй байна.

Мөн сумдын Засаг дарга нар ИТХ-аар батлагдсан 7, боловсруулах шатандаа байгаа 9 дэд хөтөлбөрт ажлын хэсэг байгуулаагүй, төлөвлөгөө боловсруулаагүй байна.

1.2 Төсөл боловсруулах төлөвлөгөөний чухал хэсэг болох нөхцөл байдлын дүн шинжилгээг журмын дагуу хийгээгүй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журмын 3.18.1 дэх заалтад “төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд **нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг боловсруулах хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгах**”-аар журамлагдсан боловч аймаг, сумдын Засаг дарга нарын боловсруулж, ИТХ-аар батлуулсан 14 дэд хөтөлбөрүүдийг боловсруулах төлөвлөгөө гаргаагүй учир дээд дурдсан асуудлууд хийгдээгүй байна.

Хэдийгээр аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан 14 дэд хөтөлбөрийн боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөө хийгдээгүй, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хугацаа, хариуцах, оролцох талын нэрийг тусгаагүй ч дараах 5 дэд хөтөлбөрүүдийн төслийг боловсруулахдаа нөхцөл байдлын дүн шинжилгээ хийсэн байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-аар батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх”, “Сүрьеэгүй Сэлэнгэ”
- Мандал сумын “Ном”,
- Орхон сумын “Амны хөндий”, “Ногоон төгөл” дэд хөтөлбөр

Дараах 7 дэд хөтөлбөрүүдийн эдийн засаг, нийгэмд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг урьдчилан үнэлээгүй, мэдээллийн эх сурвалжийг хаанаас авсан нь тодорхойгүй зэргээр нөхцөл байдлын дүн шинжилгээг хангалтгүй хийсэн байна. Үүнд:

- *Аймгийн ИТХ-аар батлагдсан “Эрчимжсэн үхрийн аж ахуй”, “Манай гудамж миний гэр”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”*
- *Алтанбулаг сумын “Хүүхэд болох багаасаа”,*
- *Мандал сумын “Хүүхэд хамгаалал”*
- *Түшиг сумын “Түшигийн зөгий”,*
- *Орхонтуул сумын “Өсвөр үе,хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” зэрэг дэд хөтөлбөр*

Дараах 2 дэд хөтөлбөрүүдэд нөхцөл байдлын шинжилгээ хийгээгүй байна Үүнд:

- *Аймгийн ИТХ-аар батлагдсан “Багш сурагч солилцоо”, “Авлигын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөр.*

Аймаг, сумдын Засаг дарга нарын боловсруулж, ИТХ-аар батлуулсан дээрх 14 хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх бодлогуудыг дэд хөтөлбөр тус бүрд боловсруулсан байна.

1.3 Сумдын Засаг дарга нарын боловсруулж, батлуулсан хөтөлбөрүүдэд нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу хийгээгүй бөгөөд төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна.

Хөгжлийн бодлого боловсруулах, нийтлэг журмын 5.24 дүгээр заалтад “төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан” байхаар журамлагдсан байдаг.

Аймгийн Засаг даргын боловсруулж, батлуулсан хөтөлбөрүүдэд нөлөөллийн урьдчилсан үнэлгээ бүрэн хийгдсэн бол сумдын Засаг дарга нарын боловсруулсан дараах хөтөлбөрүүдэд хийгдээгүй буюу хийгдсэн ч хангалтгүй байна.Үүнд:

- *Түшиг сумын “Түшигийн зөгий” дэд хөтөлбөрт хийгдээгүй,*
- *Мандал сумын “Ном” дэд хөтөлбөрөөс бусад бүх дэд хөтөлбөрүүдэд эдийн засаг, нийгэм, байгаль орчин, санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн түвшинг тогтоогоогүй, өмнө хийсэн судалгаа, мэдээлэлд үндэслэсэн талаарх мэдээлэл тодорхойгүй зэргээр нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хангалтгүй хийсэн байна.*

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журмын 11.64 дэх заалтад “**үндсэн чиглэлийн төсөлд тусгах арга хэмжээг энэхүү журмын 7 дугаар хавсралтад нийцүүлэн боловсруулах**”-аар журамласны дагуу аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг дээрх хавсралтын дагуу боловсруулсан боловч шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тусгаагүй байна.

Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн ерөнхий бүтэц агуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дараах бүтцээр боловсруулж болохоор журамлагдсан байна. Үүнд:

- *Нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл*

- *Хоёрдугаар бүлэг.Эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилго,тэргүүлэх зорилтууд*
- *Гуравдугаар бүлэг.Нийгмийн хөгжлийн бодлогын зорилго,тэргүүлэх зорилтууд*
- *Дөрөвдүгээр бүлэг.Байгаль орчны бодлогын зорилго,тэргүүлэх зорилтууд*
- *Тавдугаар бүлэг.Засаглалын бодлогын зорилго,тэргүүлэх зорилтууд*
- *Зургаадугаар бүлэг.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,үнэлгээ*

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг дээрх бүтэц, агуулгыг багтааж, 3 бүлэг, 197 зорилттой, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 3-5 бүлэгтэй, 98-136 зорилт хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 8 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу боловсруулах ёстой атал аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтын дагуу боловсруулаагүй, зөвхөн бодлогын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх байгууллагыг л тусгасан байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Алтанбулаг, Баянгол, Сант, Сүхбаатар, Хүдэр, Цагааннуур, Шаамар сум хийж батлаагүй, Баруунбүрэн, Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Түшиг сумд зорилт, арга хэмжээг тодорхойлсон боловч хэрэгжүүлэх хугацаа, хөрөнгийн эх үүсвэр, хүрэх үр дүн, төсөв, хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой тусгаагүй, хангалтгүй боловсруулсан байна.

Харин Сайхан, Мандал сумд уг хавсралтын дагуу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулжээ.

Аймаг, сумын Засаг дарга нарын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг тусгасан бол Алтанбулаг, Сүхбаатар, Хүдэр сумд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна.

Аймаг, сумын ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийг олон нийтээр хэрхэн хэлэлцүүлсэн нь дараах байдалтай байна.Үүнд:

- *Аймгийн Засаг даргын боловсруулж, батлуулсан “Эрчимжсэн үхрийн аж ахуй”, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх”, “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийн төслийн талаар төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдээс санал авсан,*
- *“Манай гудамж миний гэр, “Багш сурагч солилцоо”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Авлигын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийн төслийн талаар төрийн байгууллага, иргэдээс санал авсан боловч мэргэжлийн холбоодоос санал аваагүй,*
- *Мандал, Орхон, Орхонтуул, Түшиг сумд ИТХ-аар баталсан 7 дэд хөтөлбөрийн төслийн саналыг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг огт зохион байгуулаагүй байна.*

1.4 Аймаг, сумдын Засаг дарга нарын боловсруулж, ИТХ-аар батлуулсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцож, тусгаагүй байна.

Аймаг, сумдын Засаг дарга нарын боловсруулж, ИТХ-аар батлуулсан дэд хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг бодитой тусгасан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

“Бодлогын зорилго, зорилт”: “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх”, “Сүрьеэгүй Сэлэнгэ”, “Ном”, “Түшигийн зөгий” хөтөлбөрөөс бусад хөтөлбөрийн төслүүдэд бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон боловч хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжилд гарах үр дүн, өөрчлөлтийг бодитой тусгаагүй байна. Аймгийн болон сумын дэд хөтөлбөрийн төслүүдийн зорилго, зорилт нь Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой уялдаатай боловсруулагдсан байна.

“Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа”: Батлагдсан нийт дэд хөтөлбөрийн төсөлд бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрд зорилт тус бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна.

“Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт”: Мандал сумын “Хүүхэд хамгаалал”, Орхон сумын “Амны хөндий”, “Ногоон төгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлоогүй, “Эрчимжсэн үхрийн аж ахуй”, “Манай гудамж, миний гэр”, “Багш сурагч солилцоо”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Авлигын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Амны хөндий”, “Ногоон төгөл” хөтөлбөрийн зорилт бүрийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх нөлөөг тодорхойлж, тухайн үр нөлөө бүрт шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

“Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр”: Батлагдсан бүх дэд хөтөлбөрийн төсөлд тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг бодлогын зорилт тус бүрээр тусгаагүй байна.

1.5 Аймаг, сумдын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг холбогдох шатны ИТХ-аар батлуулсан байна.

Аудитад хамрагдсан хугацаанд Сэлэнгэ аймагт “Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт” боловсруулагдаагүй байна.

Харин Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15.2 дахь “.... Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна”, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 9.46 дахь “Шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг Засаг дарга боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ” гэсэн заалтуудын дагуу аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд, аймаг, сумдын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслүүдийг холбогдох шатны ИТХ-д хүргүүлж, батлуулсан байна.

1.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага хууль, журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг нэгтгэн боловсруулах чиг үүргийг аймагт ЗДТГ-ын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний алба, сумдад Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, төрийн захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан зэрэг албан тушаалтнууд гүйцэтгэж байна.

Аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг тусгайлан байгуулаагүйгээс түүнийг нэгтгэн боловсруулах чиг үүргийг дээр дурдсан албан тушаалтнууд гүйцэтгэсэн байна.

Аймгийн ИТХ-аар баталсан 2 хөтөлбөрийн төсөлд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгээгүй бөгөөд бусад дэд хөтөлбөрт хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ нь тухайн баримт бичигт тусган шийдвэрлэх асуудал тодорхой бус, өмнө нь уг асуудлаар хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, статистик түүвэр судалгаа, олон нийтийн санал шүүмжлэлд үндэслэсэн эсэхийг нотлох баримт муутай хийгдсэн байна.

Аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд Алтанбулаг, Сүхбаатар, Хүдэр сумаас бусад нь төрийн байгууллага, иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан саналыг тусгасан байна. Хэдийгээр төрийн байгууллага, иргэдээс санал авч тусгасан боловч мэргэжлийн холбоодоос санал авах ажлыг хангалтгүй зохион байгуулжээ. Мандал, Орхон, Түшиг сумдын ЗДТГ нь дэд хөтөлбөрийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажил зохион байгуулаагүй байна.

Сумдууд бодлогын баримт бичгийн бодлогын хувилбарт нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгээгүй байна.

Дэд хөтөлбөрүүдэд зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой хэмжээгээр тодорхойлж байгаа боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.

Аймгийн Засаг дарга нь үйл ажиллагааны хөтөлбөрийг түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан бол Мандал, Сайхан сумдын засаг даргаас бусад нь дэд хөтөлбөрийн жагсаалт гаргаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаагүй байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт болон төслийг нэгтгэн боловсруулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Бүлэг 2

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үү?

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах 2 өөр чиг үүргийг давхардуулан гүйцэтгэж байна.

2.1. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг баталсан хугацаанд тайлагнаагүй байна.

Аймаг, сумдын хэмжээнд хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэх үүргийг аймагт ЗДТГ-ын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний алба, сумдад Засаг даргын орлогч, ЗДТГ дарга, төрийн захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан зэрэг албан тушаалтнууд гүйцэтгэж байна.

Аудитын хамрах хугацаанд дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайланг гаргасан байна.

Аймгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Сэлэнгэ аймагт хамааралтай заалтуудын биелэлт,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн Сэлэнгэ аймагт хамааралтай зорилт, арга хэмжээний хэрэгжилт,
- Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт,
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт.

Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 28 дэд хөтөлбөр хэрэгжиж байгаагаас шинээр батлагдсан, тайлагнах хугацаа болоогүй 7, тайлагнах хугацааг тодорхой тусгаагүй 12, жил бүр тайлагнах 8, хагас бүтэн жилээр тайлагнах 1 дэд хөтөлбөр байна. / Хавсралт 3 /

Үүнээс 13 дэд хөтөлбөрийг огт тайлагнаагүй, 3 дэд хөтөлбөрийн тайланг эцэслээгүй байгаа бөгөөд 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан байна.

Сумдын хэмжээнд мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлогын баримт бичиг:

Сумын Засаг даргын 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, төрийн захиргаа, хууль эрх зүйн болон нийгмийн бодлогын мэргэжилтнүүд тус тус нэгтгэн тайлагнасан бол дараах баримт бичгүүдийн тайлагнал хангалтгүй байлаа. Тухайлбал:

- Жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор тайлагнаж, ИТХ-аар хэлэлцүүлэх ёстой ч Алтанбулаг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Орхонтуул, Сүхбаатар, Түшиг сумд өнөөг хүртэл тайлагнаагүй,
- Мандал, Орхонтуул, Орхон, Түшиг зэрэг сумдад хэрэгжиж байгаа 13 дэд хөтөлбөрийн биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнахаар баталсан ч огт тайлагнаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

д/д	Сумын нэр	Дэд хөтөлбөр	Тайлагнах хугацаа	Тайлагнасан байдал
1		ИТХТ-ийн 2015.09.02 №65. "Архидалтай тэмцэх хөтөлбөр" 2015-2019 онд хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөг жил бүр ИТХ-аар батлуулж, тайлагнах, иргэдэд мэдээлэх.	Тайлагнаагүй

2	Мандал	ИТХТ-ийн 2015.09.02 №68 "Цэвэр Хараа гол" 2014-2016, 2017-2019 үе шаттай хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийг жил бүр нэгтгэн гаргаж сумын ИТХ, аймгийн ЗД, ИТХ-д тайлагнана гэсэн байна.	Тайлагн аагүй
3		ИТХТ-ийн 2015.05.07 №46 "Сургалтын чанар" 2015-2019 онд хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн явц, үр дүнг хичээлийн жилийн эцэст ИТХ-д тайлагнах.	Тайлагн аагүй
4		ИТХТ-ийн 2014.06.12 №216 "Өнөөдрийн хүүхэд-Маргаашийн ирээдүй"	Хэрэгжих хугацаа, тайлагнах хугацаа тодорхойгүй.	Тайлагн аагүй
5		ИТХТ-ийн 2014.12.15 №255 "Суманд спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай" 2015-2019 онд хэрэгжүүлнэ	Тайлагнах хугацаа тодорхойгүй.	Тайлагн аагүй
6		Сумын Засаг дарга /Н.Нямдаваа/-ын 2015.02.25 №114 "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах" 2015-2019 онд хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг жил бүр гаргаж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж албан хаагчдад тайлагнана гэсэн байна.	Тайлагн аагүй
7	Орхон	Хамран сургалтыг нэмэгдүүлэх хөтөлбөр	2012-2016 онд хэрэгжиж дууссан. 2017 оноос дахин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн	Тайлагн аагүй
8		ИТХ-ын 2017.03.15 №-21 дүгээр тогтоол "Хүүхдийн амны хөндийн өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх" хөтөлбөр 2017-2020 онд хэрэгжинэ.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг, холбогдох төсвийн байгууллагуудын менежерийн жил бүрийн үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана	Тайлагн аагүй
9		ИТХ-ын 2017.03.15 №-20 дугаар тогтоол "Ногоон төгөл" хөтөлбөр 2017-2027 он хүртэл хэрэгжинэ.	Тайлагнах хугацааг тодорхой тусгаагүй.	Тайлагн аагүй
10		ИТХ-ын 2015.03.11 №-67 дугаар тогтоол "Амьдралын төгөл" хөтөлбөр /хэрэгжиж дуусах хугацаа хязгааргүй/	Тайлагнах хугацааг тодорхой тусгаагүй.	Тайлагн аагүй
11	Орхонт уул	ИТХ-ын 2014.13.26 №-38 дугаар тогтоол "Архигүй Орхонтуулчууд" хөтөлбөр 2014-2016 он хүртэл хэрэгжсэн. 2017 оноос дахин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн	Хэрэгжилт, үр дүнг хагас жил бүр ИТХ-д тайлагнана.	Тайлагн аагүй
12		ИТХ-ын 2016.04.11 №-86 дугаар тогтоол "Өсвөр үе хүүхэд, залуусын хүмүүжил, хөгжлийг дэмжих" хөтөлбөр 2016-2018 он хүртэл хэрэгжинэ.	Хэрэгжилт, үр дүнг жил бүр ИТХ-д тайлагнана.	Тайлагн аагүй
13	Түшиг	ИТХ-ын 2017.02.14 №-24 дүгээр тогтоол "Түшигийн зөгий" хөтөлбөр 2017-2020 онд хэрэгжинэ	Хэрэгжилт, үр дүнг хагас, бүтэн жил бүр ИТХ-д тайлагнана.	Тайлагн аагүй

2.2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг шинэчлэн батлагдсан хууль, журамтай нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аймаг, сумын хөгжлийн бодлогын баримт, бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зохих байгууллагад танилцуулах ажлыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14.6, 15.7, 15.8, 16.5, Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 7.6.4 дэх заалтуудын дагуу зохион байгуулахаар зохицуулсан байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг шинэчлэн баталсан тул хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн 2016 оны хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлжээ.

Аймгийн ИТХТ-ийн 2007 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцад 2012, 2021 онуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр тусгасны дагуу эхний шатыг 2012 онд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний албанаас 78.5 хувиар дүгнэж, цаашид 2-р үе шатны зорилтын хэрэгжилтийг хугацааны эцэст бус, жил бүр, эсхүл 2 жилд нэг удаа хяналт тавьж байхаар дүгнэлт гаргасан байна.

Гэвч уг дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүйгээс "Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцад өнөөг хүртэл дахин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, 2016 оноос мөрдөгдөж байгаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцүүлээгүй байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг жил бүр үнэлж, ИТХ-д танилцуулан, Засгийн газарт хүргүүлэх ёстой ч 2016 оны хэрэгжилтийн явцыг хуучин журмын дагуу үнэлсэн боловч Засгийн газарт хүргүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 28 дэд хөтөлбөр хэрэгжиж байгаагаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй 20, хэрэгжиж дууссан, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болсон 8 дэд хөтөлбөр байна. /Хавсралт 1, 3./

Үүнээс 3 дэд хөтөлбөрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлсэн бол "Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар", "Ахуйн үйлчилгээ", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах", "Олон нийтийн оролцоо-Төрийн үйлчилгээ", "Үндэсний сурын харвааг хөгжүүлэх" зэрэг 5 дэд хөтөлбөр хэрэгжээд дууссан ч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэд хөтөлбөрийн нэр, хугацааг зэргийг тодорхой тусгаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 1/258 дугаар албан бичгээр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлжээ.

Сумдад Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдээс гадна Хүдэр суманд 2014-2023 онд хэрэгжүүлэх "Сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө" буюу дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мандал, Орхон, Орхонтуул, Түшиг зэрэг сумдад шинээр баталсан 7, өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 8 дэд хөтөлбөр тус тус хэрэгжиж байна.

Үүнээс сумдын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016-2017 онд шинээр батлагдсан 7 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй байна.

Харин эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дэд хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээг огт хийгээгүй байна. Тухайлбал:

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл:

- Аудитад хамрагдсан сумд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг үнэлж, “Хангалттай” гэж дүгнэн ИТХТ-ийн хурлаар баталгаажуулжээ. Гэвч Сайхан, Хүдэр, Цагааннуур сумдаас бусад сумд хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитоор хийж, баталгаажуулаагүй байна.

Дэд хөтөлбөрүүд:

Сумдад хэрэгжиж байгаа зарим дэд хөтөлбөрүүдэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсгийг тодорхой тусгаагүй, заримд нь тусгасан ч хэрэгжилтийг хангаагүй, аймгийн ЗДТГ-т тайлан хүргүүлдээгүй зэрэг байдал нийтлэг ажиглагдаж байлаа. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.

д/д	Сумын нэр	Дэд хөтөлбөр	Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар тусгасан эсэх	Хэрэгжилтийн байдал
1	Мандал	ИТХТ-ийн 2015.09.02 №65. "Архидалтай тэмцэх хөтөлбөр" 2015-2019 онд хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөг жил бүр ИТХ-аар батлуулах, хяналт шинжилгээ-үнэлгээг жил бүр хийж, иргэдэд мэдээлнэ гэсэн байна.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.
2		ИТХТ-ийн 2015.09.02 №68 "Цэвэр Хараа гол" 2014-2016, 2017-2019 үе шаттай хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийг жил бүр нэгтгэн гаргаж сумын ИТХ, аймгийн ЗД, ИТХ-д тайлагнана гэсэн байна.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.
3		ИТХТ-ийн 2015.05.07 №46 "Сургалтын чанар" 2015-2019 онд хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн явц, үр дүнг хичээлийн жилийн эцэст ИТХ-д тайлагнах.	Хугацаа болоогүй.
4		ИТХТ-ийн 2014.06.12 №216 "Өнөөдрийн хүүхэд-Маргаашийн ирээдүй"	Хэрэгжих хугацаа, тайлагнах, хяналт шинжилгээ хийх хугацаа тодорхойгүй.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.
5		ИТХТ-ийн 2014.12.15 №255 "Суманд спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай" 2015-2019 онд хэрэгжүүлнэ	Тайлагнах, хяналт-шинжилгээ хийх хугацаа тодорхойгүй.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.
6		Сумын Засаг дарга /Н.Нямдаваа/-ын 2015.02.25 №114 "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах" 2015-2019 онд хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг жил бүр гаргаж, хэрэгжилтийг хагас хагас бүтэн жилээр дүгнэж албан хаагчдад тайлагнана гэсэн байна.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.
7	Орхон	Хамран сургалтыг нэмэгдүүлэх хөтөлбөр	Хэрэгжих хугацаа, тайлагнах, хяналт шинжилгээ хийх хугацаа тодорхойгүй.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.
8	Орхон туул	ИТХ-ын 2015.03.11 №-67 дугаар тогтоол “Амьдралын төгөл” хөтөлбөр /хэрэгжиж дуусах хугацаа хязгааргүй/	Тайлагнах болон хяналт шинжилгээ хийх хугацааг тодорхой тусгаагүй.	Дүгнэсэн тайлан ирүүлээгүй.

Хүснэгтээс харахад Мандал суманд хэрэгжиж байгаа "Суманд спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай", "Өнөөдрийн хүүхэд-Маргаашийн ирээдүй", Орхон суманд хэрэгжиж байгаа “Хамран сургалтыг нэмэгдүүлэх хөтөлбөр”, Орхонтуул суманд хэрэгжиж байгаа “Амьдралын төгөл” зэрэг 4 дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа тодорхойгүй, бусад 4 хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

2.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнах үүрэг бүхий албан тушаалтнууд нь хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг давхардуулан гүйцэтгэж байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн, тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд ЗДТГ-ын даргаар хянуулан, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэдэг байна.

Сумдад хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг нэгтгэн тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг ихэвчлэн 1-2 мэргэжилтэн давхар гүйцэтгэж байгаа бөгөөд дүнг Засаг дарга болон Засаг даргын зөвлөлийн хурлаар хянан шийдвэрлэдэг байна.

Ингэж нэгтгэн ,тайлагнах мэргэжилтэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хийсэн үнэлгээний дүнг Засаг дарга өөрчилдөг зэрэг нь сумдад хэрэгжиж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөө бодитой тайлагнагдахгүй, үнэн зөв үнэлэгдэхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Сумын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий ажилтнуудыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3.

д/д	Сумдын нэр	Хөгжлийн бодлого	Хөгжлийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнадаг мэргэжилтэн	Хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг мэргэжилтэн	Хяналт шинжилгээ, үнэлгээг эцэслэн шийдэж, мэргэжилтний хийсэн үнэлгээнд өөрчлөлт оруулдаг эсэх
1	Алтанбулаг	ЗДҮАХ	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Засаг дараг /ЗД/ эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	Засаг даргын орлогч /ЗДО/	ЗДО	
2	Баруунбүрэн	ЗДҮАХ	Төрийн захиргаа, хууль эрх зүйн мэргэжилтэн /ТЗХЭЗМ/	ЗДО	Дүнг ЗД-ын зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ	ЗДО	
		ДХ	ТЗХЭЗМ	ЗДО	
3	Баянгол	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ЗДО	ЗДО	
4	Жавхлант	ЗДҮАХ	ТЗХЭЗМ, ХАА-н мэргэжилтэн	ТЗХЭЗМ, ХАА-н мэргэжилтэн	Дүнг ЗД-ын зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ, ХАА-н мэргэжилтэн	ТЗХЭЗХ, ХАА-н мэргэжилтэн	
5	Зүүнбүрэн	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	Дотоод аудитын баг улирал бүр	

		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ	Дотоод аудитын баг улирал бүр	Дүнг ЗД-ын зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
6	Мандал	ЗДҮАХ	ЗДТГ-ын дарга	Салбарын мэргэжилтнүүд өөрсдөө үнэлгээгэ тавина	ЗД-ын зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Үнэлгээнд өөрчлөлт оруулдаггүй. ЭЗНХҮЧ-ийг ЗДО хуралд тайлагнана.
		ЭЗНХҮЧ	ЗДТГ-ын дарга	Салбарын мэргэжилтнүүд өөрсдөө үнэлгээгэ тавина	
		ДХ	ЗДТГ-ын дарга	Холбогдох мэргэжилтнүүд	
7	Орхон	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга	ЗД-эцэслэн шийдвэрлэнэ
		ЭЗНХҮЧ	ЗДО	ЗДТГ-ын дарга	
		ДХ	ТЗХЭЗМ, ХАА-н мэргэжилтэн	ЗДТГ-ын дарга	
8	Орхонту ул	ЗДҮАХ	ТЗХЭЗМ, Нийгмийн ажилтан	ТЗХЭЗХ, Нийгмийн ажилтан	ЗД-ын зөвлөлөөр эцэслэн шийдвэрлэнэ
		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ, Нийгмийн ажилтан	ТЗХЭЗХ, Нийгмийн ажилтан	
9	Сант	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ЗДТГ-ын дарга	ЗДТГ-ын дарга	
10	Сайхан	ЗДҮАХ	ЗДО	ЗДО	ЗДТГ-ын дарга хянаж, ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	
11	Сүхбаатар	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга хянаж, ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	
12	Хүдэр	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга хянаад, Засаг даргад танилцуулна. Үнэлгээнд өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	Засаг даргын орлогч	Засаг даргын орлогч	
13	Түшиг	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга, ЗДО	ЗДТГ-ын дарга хянаж, ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга, ЗДО	
		ДХ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга, ЗДО	
14	Цагааннуур	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга хянаж, ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ЗДТГ-ын дарга	ЗДТГ-ын дарга	
15	Шаамар	ЗДҮАХ	ТЗХЭЗМ	ТЗХЭЗМ	ЗДТГ-ын дарга хянаж, ЗД эцэслэн шийдвэрлэнэ. Өөрчлөлт оруулна.
		ЭЗНХҮЧ	ЗДТГ-ын дарга	ЗДТГ-ын дарга	

Хүснэгтээс дүгнэвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Хөжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийг нэгтгэн тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Баянгол, Жавхлант,

- Орхонтуул, Сант, Сайхан, Сүхбаатар, Хүдэр, Цагааннуур, Шаамар зэрэг 10 суманд нэг мэргэжилтэн гүйцэтгэдэг,
- Баруунбүрэн, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Түшиг зэрэг 5 суманд дээрх чиг үүргийг 2 өөр албан тушаалтан хийж гүйцэтгэдэг байна.

Аудитын явцад сумын ЗДТГ-ын дарга, холбогдох мэргэжилтнүүдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Засаг дарга, Засаг даргын зөвлөлийн хурлын зүгээс ямар үндэслэлээр, хэрхэн өөрчлөлт оруулж байгаа талаар асуулга авахад Мандал сумаас бусад суманд өөрчлөлт оруулдаг гэх бөгөөд өөрчлөх үндэслэл, тооцоолол зэрэг нотлох баримт баримтыг үйлдэж, ажлын баримт болгон архивлаж хэвшээгүй байна.

Цаашид Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу² захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариусан нэгж, ажилтан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, ажилтан нь хяналт-шинжилгээ үнэлгээг хийж байх шаардлагатай байна.

Бүлэг 3

Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагууд хангалтгүй зохион байгуулж байна.

3.1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажил хангалтгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх сурталчлах ажлыг зохион байгуулах үүргийг нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулах”-аар зохицуулагдсан байдаг.

Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд мэдээлсэн байдлыг авч үзвэл:

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг товхимол хэлбэрээр хэвлэж, 1000 орчим өрхөд тарааснаас гадна 17 сумын иргэдтэй уулзалт хийж сурталчилсан байна. Харин эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дэд хөтөлбөрүүдийг аймгийн албан ёсны цахим хуудсанд тавьснаас бусдаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулаагүй байна.

² “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.4. Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

- Мандал, Сайхан сум цахимаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, Жавхлант Орхон, Орхонтуул, Хүдэр сумд орон нутгийн сонинд нийтлэх, гарын авлага боловсруулж, иргэдэд тараах зэргээр тус бүр 2-4 удаа сурталчилсан,
- Баянгол, Баруунбүрэн, Сант, Түшиг, Цагааннуур, Шаамар сумд ард иргэдтэй уулзалт ярилцлага хийх хэлбэрээр зохион байгуулсан,
- Алтанбулаг, Зүүнбүрэн, Сүхбаатар сумд нь мэдээлэл, сурталчилгаа огт хийгээгүй байна.

Аймгийн хэмжээний бүх сумд цахим хаягтай боловч хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг Мандал, Сайхан сумдаас бусад нь цахим хаягаар олон нийтэд мэдээлээгүй байна.

3.2. Орон нутгийн ИТХ, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ нь бодлогын бичиг баримтуудыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллаганы хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хагжүүлэх үндсэн чиглэл болон батлагдсан дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор Засаг дарга түүний харьяа агентлаг байгууллага, холбогдох албан тушаалтанд хариуцуулжээ.

Гэвч Алтанбулаг, Сант, Сүхбаатар Цагааннуур, Шаамар сумд нь олон нийтэд мэдээлэх, сурталчлах үүрэг бүхий албан хаагч, байгууллагыг томилоогүй байна.

Аудитын явцад аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон батлагдсан дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд хэрхэн мэдээлсэн, сурталчилсан талаар хариуцсан албан тушаалтнуудаас асуулга авч ярилцлага хийхэд улирал тутам ард иргэдэд сонин хэвлэл, гарын авлага тараах, ард иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах хэлбэрээр мэдээлж байгаа гэсэн тайлбар өгсөн болно.

Хэдийгээр улирал тутам олон нийтэд мэдээлэл, сурталчилгаа хийж байгаа гэх боловч эдгээрийг нотлох баримт хангалтгүй байгаагаас албан тушаалтнууд хууль журамд заасан үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй гэж үзэж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Дэд хөтөлбөрийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулаагүй байна.
- Аймаг, сумдын Засаг дарга нь төсөл боловсруулах ажлын хэсэг томилоогүйгээс төсөл боловсруулах төлөвлөгөөний чухал хэсэг болох нөхцөл байдлын дүн шинжилгээг журам зааврын дагуу хийгээгүй байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээг журамд заасны дагуу хийгээгүй, төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна.

- Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон боловч хөрөнгийн хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг тусгаагүй байна.
- Сумын Засаг дарга нар дэд хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулж, ИТХ-р батлуулаагүй байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнууд хууль, журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.
- Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг баталсан хугацаанд тайлагнаж хэвшээгүй байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг шинэчлэн батлагдсан хууль, журамтай нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.
- Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий алба, албан тушаалтнууд нь биелэлтийг нэгтгэн тайлагнах үүргийг давхар гүйцэтгэж байна.
- Орон нутгийн ИТХ, Засаг дарга, түүний харьяа агентлаг, байгууллага, ЗДТГ нь бодлогын бичиг баримтуудыг олон нийтэд мэдээлэх сурталчлах үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

АЛБАН ШААРДЛАГА

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитад шаардлагатай баримт, материалыг ирүүлээгүй Ерөө, Хушаат сумдын Засаг дарга нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаад:

1. Шинээр боловсруулах хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийн төслийг журамд заасны дагуу холбогдох мэдээлэл, баримтыг үндэслэн хянаж, баталж байх.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

1. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавьж байх.
2. Шинээр боловсруулж, батлуулах хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийн төлөвлөлтийн үе шатны ажлуудыг хууль, журамд нийцүүлэн гүйцэтгэх.
3. Хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцож, батлуулж байх.
4. Хөгжлийн бодлогын баримт, бичгийн төслийг холбогдох байгууллагад хүргүүлж, хянуулсны үндсэн дээр батлуулах.
5. Хөгжлийн бодлогын баримт, бичгийн хэрэгжилтэд хууль, журамд заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнаж байх.

6. Хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийг тайлагнах, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийн давхардлыг арилгах.
7. ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэд хөтөлбөрүүдийн жагсаалт, хугацаа зэргийг тодорхой тусгаж, хэрэгжүүлж байх.
8. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, сурталчлах үүрэг бүхий албан тушаалтнууднаар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журмуудыг судлуулах.
9. Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих үе шатны ажлын баримтуудыг эмхэлж, цэгцлэн архивын нэгж болгон хадгалж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Б.НАРАНЧИМЭГ

Б.ЭРДЭНЭЗУЛ

Ж.ЦОГТ

Тайлангийн төсөлд ирүүлсэн санал:



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834

2017.12.18 № 5/134
танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай
хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  А.ЭРДЭНЭГЭРЭЛ

